

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨМА-2022/30-14-ШТА-ГА

ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Даланзадгад хот 2022 он



Дарга, Тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Сүрэнжаргал

Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn

Аудитор Н.Хулан

Утас: 70533552 Цахим хаяг: Khulann@audit.gov.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр	Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын менежер: Т.Хонгорзул	Хүснэгт, график, зургийн жагсаалт	2
Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3-4
Аудитор: Н.Хулан Т.Хишигбат	Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу хуваарилсан байна	5
	1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу төлөвлөсөн байна	5-6
	1.2 Иргэдийн санал аваагүй зарим төсөл арга хэмжээг баталсан байна	9-10
	Бүлэг 2. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг журмын дагуу хэрэгжүүлсэн байна	10
	2.1 Төсөл арга хэмжээг холбогдох хууль, огтоомжийг баримталж хэрэгжүүлсэн байна	10-11
	2.2 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна	11-12
	2.3 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалтад хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.	12-13
2022 оны 05 дугаар сар	Бүлэг 3. Сангийн хөрөнгийн зарцуулалтыг журмын дагуу тайлагнаагүй байна	14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу.	3.1 Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналт хангалтгүй байна.	14-15
	3.2 Сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар журмын дагуу тайлагнаагүй байна.	15-16
Тайланг ӨМТАГ-ын www.umnugovi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү.	Дүгнэлт	17
	Зөвлөмж	17
	Холбогдох байгууллагын санал	18
	Дарга, Тэргүүлэх аудиторовын тушаал	19
Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 305 тоот	Хавсралт №1	20
	Хавсралт №2	21
	Хавсралт №3	22

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үнэлгээ
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

Хүснэгт, Дүрслэл, графикийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Сумдад олгосон ОНХС-ийн хуваарилалт	6
Хүснэгт 2	Сумдад олгосон санхүүжилт	6
Хүснэгт 3	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах арга хэмжээнд төлөвлөн санхүүжүүлсэн зарим төсөл арга хэмжээ	8
График 1	Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэр	5
График 2	/ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг Шилэн дансны цахим системд хугацаа хоцроосон байдал/	
Зураг 1	Ноён сумын Спорт цогцолбор барих ажлын бодит гүйцэтгэл	12
Зураг 2	Баяндалай сумын Баяр наадмын талбайг нэгтгэх ажлын зураг, бодит гүйцэтгэлийг харьцуулсан байдал	13
Зураг 3	Баяндалай сумын Баяр наадмын талбайг нэгтгэх ажлын зураг, бодит гүйцэтгэлийг харьцуулсан байдал	13
Зураг 4	Булган сумын “Халуун усны засварын ажлын ашиглалт	13

Аудитын зорилт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэв.

Зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд шалгах хуудсаар нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Хамрах хүрээ:

ОНХС-ийн 2021 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал болон аймаг, сумын ИТХ, ЗДТГ, багийн ИНХ, Засаг даргын холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

Хүндрэл, бэрхшээл:

Мандал-Овоо сумын 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн баримтыг холбогдох албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас үрэгдүүлсэн шалтгаанаар Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлээгүй тул аудит хийгдээгүй болно.

Мөн шатахуун болон албан томилолтын зардал хязгаарлагдмал байгаагаас зарим сумдын сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг талбарт ажиллан шалгаагүй нь тайлан бичихэд хүндрэл үүсгэж байлаа.

**Аудитад
ашигласан
шалгуур:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/;
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- МУ-ын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.
- Өмнөговь аймгийг 2021 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө

**Аудит хийсэн
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул арга зүйгээр хангаж, ахлах аудитор Д.Сүрэнжаргал, аудитор Н.Хулан, Т.Хишигбат нар 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу хуваарилсан байна

1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу төлөвлөсөн байна

1.1.1 ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.1¹, 60.2.2² 60.2.4³, 60.2.5⁴, 60.2.7⁵-д зааснаар тус тус бүрдүүлэх зохицуулалттай байна.

1.1.2 Аймгийн ИТХ-ын 2021 оны 3/2 дугаар “2021 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор Сангийн яамнаас олгох орлогын шилжүүлгийг 17,014.6 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэрийг 2,000.0 сая төгрөг баталсан байна.

1.1.3 Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод гадаадын хандив тусламжаар Манлай сум 3.8 сая төгрөг, Ханхонгор сум 106.3 сая төгрөг, Цогт-овоо сум 52.5 сая төгрөг, Хүрмэн сум 0.3 сая төгрөг байхаар тухайн шатны ИТХ баталсан байна. /Хавсралт-1/

График-1 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэр



Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын СТЦХ-ийн баримт, материал

1.1.4 Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу аймгийн ОНХС-д 8,839.2 сая төгрөг, сумдын ОНХС-д 8,175.4 сая төгрөгийг хуваарилж олгосон байна.

¹ орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг

² энэ хуулийн 59.2-т заасан хөрөнгө

³ татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр

⁴ тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг

⁵ ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

Хүснэгт-1 Сумдад олгосон ОНХС-ийн хуваарилалт

/сая төгрөг/

№	Сумын нэр	Тогтвортой амьжиргаа 3 төслийн	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл	МЕГА төслүүдээс бусад төслүүдийн АМНАТ	Итгэлцүү рээр хуваарил агдсан хөрөнгө	ОНХС-аас санхүүжих суурь зардал	Дүн
1	Баяндалай	23.5	25.3		130.3	19.7	198.8
2	Баян-Овоо	4.8	549.6		136.8	6.0	697.2
3	Булган	14.7			116.5	32.8	164.0
4	Гурвантэс	16.8	170.3	485.0	485.6	2.0	1,159.7
5	Мандал-Овоо	3.6	37.9		102.2	26.7	170.4
6	Манлай	26.1	26.8		207.6	12.4	272.9
7	Номгон	37.2	72.7		206.1	44.0	360.0
8	Ноён	16.8	120.3	2,104.0	133.4	1.2	2,375.7
9	Сэврэй	27.0	-	-	149.5	7.6	184.1
10	Ханбогд	16.6	148.9	-	478.2	9.0	652.7
11	Ханхонгор	19.2	103.3	-	106.2	13.3	242.0
12	Хүрмэн	4.1	60.2	-	119.2	8.8	192.3
13	Цогт-Овоо	3.7	49.8	-	107.5	4.4	165.4
14	Цогтцэций	53.3	191.5	222.4	294.9	9.7	771.8
15	Даланзадгад	62.8	0.1	-	498.6	6.9	568.4
	Дүн	330.2	1,556.7	2,811.4	3,272.6	204.5	8,175.4

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2021 оны 3/2 дугаар тогтоол

1.1.5 Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт-2 Сумдад олгосон санхүүжилт

/сая төгрөг/

№	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Баяндалай	198.8	198.8	100
2	Баян-Овоо	697.2	697.2	100
3	Булган	164.0	164.0	100
4	Гурвантэс	1,159.7	1,159.7	100
5	Мандал-Овоо	170.4	170.4	100
6	Манлай	272.9	272.9	100
7	Номгон	360.0	360.0	100
8	Ноён	2,375.7	2,375.7	100
9	Сэврэй	184.1	184.1	100
10	Ханбогд	652.7	652.7	100
11	Ханхонгор	242.0	242.0	100
12	Хүрмэн	192.3	192.3	100
13	Цогт-Овоо	165.4	165.4	100
14	Цогтцэций	771.8	771.8	100
15	Даланзадгад	568.4	568.4	100
	Дүн	8,175.4	8,175.4	100

Эх сурвалж: Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн харилцах

1.1.6 Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/8 дугаар тогтоолоор Сангийн яамнаас олгох ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 16,732.1 сая төгрөгөөр баталсан бол 2021 оны 3/2 дугаар

1.1.7 тогтоолоор 282.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 17,014.6 сая төгрөгөөр баталсан байна.

1.2 Иргэдийн санал аваагүй зарим төсөл арга хэмжээг баталсан байна

1.2.1 Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.2 -д заасны дагуу иргэдээс санал авч эрэмбэлсэн боловч зарим сумд журмыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:



1.2.2 Аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа саналын хуудсаар санал асуулга авах, иргэдийн саналыг эрэмбэлж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлсэн талаар баримт материал бүрдүүлсэн боловч иргэдийн оролцоо, идэвх муу байгаа нь харагдаж байна.

1.2.3 Сумдын ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч эрэмбэлээгүй байна. Үүнд:

- Гурвантэс сум 60.0 сая төгрөгийн өртөгтэй аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажил,
- Ноён сум 35.0 сая төгрөгийн өртөгтэй малын үйлдвэр угсааг сайжруулах ажил,
- Хүрмэн сум 20.0 сая төгрөгийн өртөгтэй зам засварын ажил, 10.0 сая төгрөгийн “Өвс тэжээл бэлтгэх ажил,

1.2.4 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр ойрын жилүүдэд шинээр баригдах болон засварлах барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөв боловсруулахад 20 төсөл арга хэмжээ буюу 851.4 сая төгрөгийг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1⁶, 60.11⁷ дах заалттай нийцэхгүй байна.

1.2.5 Аймгийн онцгой комиссын шийдвэрээр гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах гэсэн утгаар нотлох баримтгүй арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

1.2.6 Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах арга хэмжээний зардалд нотлох баримтгүй 12 төсөл арга хэмжээ буюу 1,074.2 сая төгрөг, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлгүй 198.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээг төлөвлөн санхүүжүүлсэн

⁶ орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ

⁷ энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

нь Гамшгийн тухай хуулийн 4.1.1⁸, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6⁹ Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3¹⁰ дахь заалттай нийцээгүй байна.

Хүснэгт-3 Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах арга хэмжээнд төлөвлөн санхүүжүүлсэн зарим төсөл арга хэмжээ

/сая төгрөг/

Д/д	Төсөл, хөтөлбөр, арга хэмжээ	Олгосон санхүүжилтийн дүн	Батлагдсан төсөв байгаа эсэх	Аймгийн Засаг даргын захирамж	Тайлбар	
1	Даланзадгад сумын 3-р сургуулийн уурын зуухны цахилгааны шугамыг шинэчлэн засварлах	89.00	төсөвгүй	36-р тогтоол		
2	Аймгийн ахмадын байрны дулааны шугамыг засварлах	23.00	төсөвтэй	36-р тогтоол		
3	Гурвантэс сумын уурын зуухны засвар үйлчилгээ, халаалтын тогооны шинэчлэлт	169.00	төсөвтэй	36-р тогтоол	Аймгийн Засаг даргын захирамжийн үндэслэл нь онцгой комиссын 36 дугаар хурлын тэмдэглэлийг тогтоол гэж буруу бичсэн.	
4	Ханбогд сумын хайрхан багийн уурын зуухны засвар үйлчилгээ, халаалтын тогооны шинэчлэлт	259.00	төсөвтэй	36-р тогтоол		
5	Ханбогд сумын төвийн уурын зуухны засвар үйлчилгээ, халаалтын тогооны шинэчлэл	323.30	төсөвтэй	36-р тогтоол		
6	Даланзадгад сумын 3-р багийн 13-р байрны шугамыг засварлах	58.60	төсөвгүй	36-р тогтоол		
7	Даланзадгад сумын ахуйн үйлчилгээний барилгын засвар	32.80	төсөвтэй	36-р тогтоол		
8	Аймгийн Хөгжимт жүжгийн театрын дулааны шугам сүлжээг засварлах	22.90	төсөвгүй	44 тогтоол		
9	Даланзадгад сумын дулааны шугам сүлжээний гэмтсэн хаалтуудыг шинээр солих	9.90	ТЭЗҮ байхгүй	36 тогтоол		
10	Даланзадгад сумын ахуй үйлчилгээний барилгын гадна дулааны засвар	18.40	ТЭЗҮ байхгүй	Онцгой байдлын газрын шийдвэр гараагүй		
11	Мандал-Овоо сумын Соёл спортын төвийн дээврийг засварлах	53.50	төсөв байгаа боловч гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй	45-р тогтоол		45 дугаар хурлын тэмдэглэлийн 2.1 Мандал-Овоо сумын Соёл спортын барилгын засварын зардлыг гамшгаас хамгаалах зардлаас гаргах
12	Даланзадгад сумын 9 дүгээр цэцэрлэгийн зүүн чиглэлийн гэмтсэн шугам сүлжээг засварлах	14.80	төсөвтэй	48-р тогтоол		
Дүн		1,074.2				

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ийн харилцахын баримт, онцгой комиссын хурлын тэмдэглэлээс

1.2.7 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх “Нутгийн хишиг” хөтөлбөр, аймаг, сумдын 2021 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд тусган аймаг 10,839.2 сая төгрөг, сумд 8,338.1 сая төгрөгөөр тухайн шатны ИТХ-аар баталсан байна.

⁸ /гамшиг/ гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг

⁹ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, ...

¹⁰ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

1.2.8 Зарим сумд ОНХС-ийн шилжих үлдэгдлийг зөрүүтэй баталсан байна. Үүнд:

- Гурвантэс сум 43.0 сая төгрөг
- Ноён сум 40.8 сая төгрөг
- Баян-Овоо сум 0.02 сая төгрөг
- Ханбогд сум 91.1 сая төгрөг

1.2.9 Аймгийн Засаг даргын чиг үүрэгт хамаарах 5,604.1 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг тусгасан байна.

Аймгийн Засаг даргын чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээ:

1

Баталсан төсөв: 5,036.6 сая төгрөг

Төсөл арга хэмжээ: Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах арга хэмжээг зохион байгуулах, ковидын цар тахлын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх

2

Баталсан төсөв: 267.5 сая төгрөг

Төсөл, арга хэмжээ: Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шимэгчтэй өвчний арга хэмжээ болон гоц халдварт, адууны нийлүүлэг паразит, бруцеллёз өвчнөөс эрүүл бүсийг баталгаажуулах тандалт шинжилгээний ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, эм био үйлдвэрлэлийн тасгийг шинээр байгуулах

3

Баталсан төсөв: 180.0 сая төгрөг

Төсөл, арга хэмжээ: Нийтийн тээврийн үйлчилгээний ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд хөнгөлөлттэй зорчсоны нөхөн олговрыг олгох

4

Баталсан төсөв: 120.0 сая төгрөг

Төсөл, арга хэмжээ: Мал аж ахуйн өвөлжилт хаваржилтын байдалтай уялдуулан халдваргүй өвчин, малын тамир тэнхээний эм бэлдмэлийн нөөц бүрдүүлэх, зүй бусаар хорогдсон малын сэг зэмийн устгал, халдваргүйтгэлийг зохион байгуулах

1.2.10 ОНХС-аас 2021 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд сумдын Засаг дарга нарын чиг үүрэгт хамаарах 197.8 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

1

Сумдын нэрс: Баяндалай, Баян-Овоо, Гурвантэс

- Мал эмнэлгийн санхүүжилт

2

Сумын нэр: Манлай

- Мал эмнэлгийн санхүүжилт
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ

3

Сумын нэр: Ноён

- Мал эмнэлгийн санхүүжилт
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах арга хэмжээг зохион байгуулах, ковидын цар тахалын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх
- Малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал

1.2.11 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хэмжээнд Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2¹¹, 4.2.3¹² дахь заалттай нийцэхгүй дараах ажлыг төлөвлөсөн байна. Үүнд:

- Ноён сум 5.0 сая төгрөгийн өртөгтэй золбин нохой, муур устгах ажил,

¹¹ ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно

¹² Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11-д зааснаас бусад төрлийн үйлчилгээний зардал

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

- Номгон сум 5.0 сая төгрөгийн өртөгтэй олон нийтийн зар, мэдээний ажил,
- Сэврэй сум 7.0 сая төгрөгийн өртөгтэй сумын орон нутгийн мэдээллийн хэрэгслийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах ажил, сумын нутаг дэвсгэрт туурайтан ан амьтан өсөн үржих нөхцөл боломжийг хангах, золбин нохой, чоно устгах ажил,

1.2.12 Дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй тухай албан шаардлагыг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

1.2.13 Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.8¹³-д заасны дагуу ОНХС-ийн шилжих үлдэгдэл 6,093.1 сая төгрөгийг дараагийн төсвийн жилийн эх үүсвэрт тусгасан байна.

1.2.14 Аймгийн ОНХС-ийн шилжих үлдэгдлийг 2,134.2 сая төгрөг, сумдын ОНХС-ийн шилжих үлдэгдлийг 3,958.9 сая төгрөгөөр төлөвлөж тухайн шатны ИТХ баталсан байна.

1.2.15 Үүнээс дүгнэхэд сангийн хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

БҮЛЭГ 2 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг журмын дагуу хэрэгжүүлсэн байна

2.1 Төсөл арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжийг баримталж хэрэгжүүлсэн байна

2.1.1 Тайлант онд 23,366.07 сая төгрөгийн 249 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулсан бөгөөд 21.3 хувь буюу 53 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 0.8 хувь буюу 2 ажлыг олон нийтийн оролцоотой, 12.0 хувь буюу 30 ажлыг харьцуулалтын аргаар, 6.8 хувь буюу 17 ажлыг хязгаарлагдмал, 59.1 хувь буюу 147 ажлыг шууд худалдан авсан байна. /Хавсралт-2/

2.1.2 Аудитад аймгийн болон 15 сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны үйл ажиллагааны баримт материалыг бүрэн хамруулж, хийгдсэн ажлуудыг газар дээр нь үзэхдээ өмнөх онуудын хяналт шалгалтад хамрагдсан байдал, эрсдэл зэргийг харгалзан үзэж 5 сумыг түүвэрт хамруулсан.

2.1.3 Аудитаар худалдан авах ажиллагаа зохион байгуулахтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Булган сумын Дал багийн гадна тохижилтын ажлын гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэх тухай захирамж гараагүй байхад гэрээ байгуулсан,
- Даланзадгад сумын Орон сууцны дээврийг засварлах зураг төсөв боловсруулах /11-28, 31-33-р байр/ ажил, Гэр хороололд ундны усны гүн өрмийн худаг гаргаж ус түгээх цахим байр барих, 8 дугаар багийн ундны усны худгийг засварлаж цахим болгох ажлын үнэлгээний хорооны гишүүн худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшээгүй,
- Ханбогд сумын төвийн авто замын зураг төсөл, төсөв боловсруулах 149.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил,
- Өмнөговь аймгийн худалдааны төв зах барих зураг төсөл боловсруулах 36.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудыг өдөр тутмын болон бусад хэвлэлд нийтлээгүй,

¹³ ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

2.1.4 Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 36.4¹⁴, 47.3.1¹⁵ заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.1.5 Санхүү хяналт, дотоод аудитын албанаас ОНХС-д хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилд тогтоосон төлбөрийн актыг ОНХС-аас барагдуулж, зориулалт бусаар зарцуулсан зөрчил давтагдан гарсан. Үүнд:

- Номгон сум 1.4 сая төгрөгийн актын төлбөр
- Баян-Овоо сум 1.9 сая төгрөгийн актын төлбөр
- Ханбогд сум 1.8 сая төгрөгийн актын төлбөр
- Булган сум 1.3 сая төгрөгийн актын төлбөр
- Булган сум 0.5 сая төгрөгийн бичиг хэргийн зардал

2.1.6 Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11¹⁶, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.7.5¹⁷ " дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

2.1.7 Иймд дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.

2.1.8 Цаашид худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

2.2 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна

2.2.1 Тайлант онд ковид цар тахал, хил гаалийн хорио цээрээс шалтгаалан аймгийн хэмжээнд дутуу хэрэгжсэн 26 төсөл арга хэмжээнд 2,501.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, он дамжин хэрэгжиж байна. /Хавсралт-3/

2.2.2 Аймаг, сумдын 2021 онд ОНХС-гийн хөрөнгөөр 204 төсөд, арга хэмжээнд 17,325.9 сая төгрөг зарцуулсан байна.

Дүрслэл-1 /Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг төрлөөр нь ангилвал/



¹⁴ Захиалагч ажлын даалгавар бэлтгэж, төсөвт өртгийг тооцоолж гаргасны дараа зөвлөхийн жагсаалтад орох саналаа ирүүлэхийг хүссэн урилгыг өдөр тутмын болон бусад хэвлэлд нийтэлнэ”

¹⁵ худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн байх

¹⁶ “Энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй.

¹⁷ “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”



267.2 сая ₮
Их засвар



756.2 сая ₮
Тоног, төхөөрөмж



948.9 сая ₮
Зураг, төсөв




432.5 сая ₮
Гүн өрмийн худаг



58.8 сая ₮
Ногоон
байгууламж



4,185.0 сая ₮
Гамшиг, ковид
урьдчилан сэргийлэх



662.0 сая ₮
Мал халдвар, мал э
мнэлгийн үйлчилгээ



516.5 сая ₮
Бусад ажил

2.2.3 Эдгээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд иргэдийн ундны усны хангамж, малчдын мал маллах нөхцөл, иргэдийг тогтвор суурьшилтай ажиллуулах боломж тодорхой хэмжээгээр сайжирсан байна.

2.2.4 Мөн аймгийн ОНХС-аас Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсэд шугам сүлжээ өргөтгөхөд 3,650.4 сая төгрөг, гэрэлтүүлэгт 1,276.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн нь гэр хороололд дэд бүтэц шийдвэрлэгдэж, иргэдийн тав тухтай амьдрах эрүүл орчин бүрдэн ЖДҮ, газар тариалан эрхлэгч нарт бизнесээ хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх таатай орчин бүрдсэн байна.

2.2.5 Харин аймаг, сумдын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нь саналыг журамд заасан үзүүлэлтүүдийн дагуу үнэлж, орон нутгийн бодлого, чиглэлтэй уялдуулсан, төслийн төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан дүн шинжилгээ хийн, дүгнэлт, зөвлөмж гаргаагүй байна.

2.3 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалтад хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна

2.3.1 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд батлагдсан зураг төсвөөс зөрүүтэй, хэрэгжилт дутуу, бодит гүйцэтгэлд хүрээгүй байхад санхүүжилтийг олгосон зөрчил давтагдсаар байна. Үүнд:

- Ноён сумын спорт цогцолбор барих ажлын гүйцэтгэл 80 хувь хүрээгүй байхад санхүүжилтийг олгосон,
- Баяр наадмын талбайг нэгтгэх ажлын магадалшгүй ажлын зардлыг 2.2 сая төгрөгөөр илүү шилжүүлсэн,
- Баяндалай сумын өмнөх оноос дамжин хийгдсэн 80.4 сая төгрөгийн өртөгтэй баяр наадмын талбайг нэгтгэх ажил зураг төсвөөс зөрүүтэй хийгдсэн,

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

Зураг-1 /Ноён сумын Спорт цогцолбор барих ажлын бодит гүйцэтгэл/



Зураг-2 /Баяндалай сумын Баяр наадмын талбайг нэгтгэх ажлын зураг, бодит гүйцэтгэлийг харьцуулсан байдал/



Зураг-3 /Баяндалай сумын Баяр наадмын талбайг нэгтгэх ажлын зураг, бодит гүйцэтгэлийг харьцуулсан байдал/




2.3.2 Зарим барилгын их засвар, гүн өрмийн худаг, зам, шугам сүлжээ, гэрэлтүүлэг, тоног төхөөрөмжүүд нь ашиглалтын явцад шаардлага хангахгүй зөрчил илэрлээ. Үүнд:

- Булган суманд хийгдсэн "Халуун усны засварын ажил"-ын гүйцэтгэл нь дотор ханын будаг хуурсан, дүүжин тааз зай завсар ихтэй, дутуу үлдээсэн, шалны түвшин буруу ус бүрэн шавхагдахгүй, плита чигжээгүй, хаалганы бариул салж унасан, үүдний хэсэг будаг хуурсан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

Зураг-5 /Булган сумын “Халуун усны засварын ажлын ашиглалт/



2.3.3 Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

2.3.4 Үүнээс харахад төсөл арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд нь ашиглалтад хүлээж аваагүй нь дээрхи төсөл арга хэмжээнүүдийн анхны тавьсан зорилго, үр дүндээ хүрэхгүй байх, төслөөс иргэдийн хүртэх үр ашиг, үр нөлөө буурах, гүйцэтгэл дутуу ажлыг улсын комисс хүлээн авсан нь зориулалтын дагуу ашиглахгүй байх эрсдэл дагуулж байна.

БҮЛЭГ 3 Сангийн хөрөнгийн зарцуулалтыг журмын дагуу тайлагнаагүй байна

3.1 Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналт хангалтгүй байна

3.1.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4 заасны дагуу хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд тус тус хяналт тавьж ажиллахаар зохицуулсан.

3.1.2 Мөн ТБОНӨХБАУХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6¹⁸ -д захиалагчийн эрх үүргийг хуульчилсан байдаг.

3.1.3 Аудитаар ихэнх сумдын хэрэгжилт хангалтгүй байгаа нь дээрх хууль, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Өмнөговь аймгийн ИТХ
- Мандал-Овоо сумын ИТХ
- Хүрмэн сумын ИТХ
- Баяндалай сумын ИТХ
- Гурван тэс сумын ИТХ
- Манлай сумын ИТХ
- Ханхонгор сумын ИТХ

3.1.4 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд ГХБХБГ захиалагчийн хяналт хийсэн байна.

¹⁸ “захиалагч нь бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавина

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

3.1.5 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд сумын ЗДТГ нь өөрөө захиалагчийн хяналтыг хийж гүйцэтгэсэн боловч үр дүнгүй байна. Үүнд:

- Манлай сумын ЗДТГ нь сумын төвөөс 5 км зайд орших цахилгаан шугамын өргөтгөл хийх ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэхдээ зөвхөн шатахууны зардалд 0.8 сая төгрөг зарцуулсан,

- Ноён сумын ЗДТГ нь спорт цогцолбор барих, зураг төсөв хийлгэх ажлын гүйцэтгэлийг буруу дүгнэсэн,

3.1.6 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний захиалагч болох аймаг, сумдын ЗДТГ нь захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй байна.

3.1.7 Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ы өдрийн 170 дугаар тогтоолоор баталсан Барилга захиалагчийн дүрмийн 2.8¹⁹ дахь заалттай нийцэхгүй байна.

3.1.8 Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 8 сумын ОНХС-ийн зарцуулалтад хяналт шалгалт хийн 210.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 520.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн байна.

3.1.9 Тус шалгалтаар зориулалт бусаар зарцуулсан хөрөнгө төлүүлэх, гэрээний хэрэгжилт хангуулаагүй, магадалшгүй ажлын зардал, зохиогчийн хяналтын зардлыг суутгаагүй зэрэг зөрчлийг илрүүлсэн байна.

3.2 Сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар журмын дагуу тайлагнаагүй байна

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланг ирүүлэх тухай аймгийн Засаг даргын 2022 оны 1-45 албан бичгээр сумдын Засаг дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийг нэгтгэн Сангийн яаманд 01/504 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

3.2.2 Тус тайланд сайн туршлага, жишээ, оновчтой саналыг тусгаагүй байгааг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

3.2.3 Сумдын санхүүгийн алба нь ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар хавсралтын дагуу Санхүү төрийн сангийн хэлтэст тайлагнаагүй байна.

3.2.4 Мөн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь ОНХС-аар 2021 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналт, шинжилгээ хийсэн боловч үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлээгүй байна.

3.2.5 Эдгээр нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.1²⁰, 9.6²¹ дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹⁹ Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4 “барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна

²⁰ Дүүргийн Төрийн сангийн хэлтэс, сумын санхүүгийн алба нь ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ журмын 10 дугаар хавсралтын дагуу аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах хугацаанд тайлагнана,

²¹ Энэ журмын 9.5-д заасны дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хүлээнэ.

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

3.2.6 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн бий болсон барилга, байгууламж, барилгын их засвар, гүн өрмийн худаг, зам, шугам сүлжээ, гэрэлтүүлэг, тоног төхөөрөмж, зураг төсөв зэрэг 13,500.6 сая төгрөгийн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

3.2.7 Хөрөнгө оруулалтын ажлуудыг санхүүгийн бүртгэл тайланд тусгахгүй орхигдуулдаг зөрчил өмнөх онуудтай харьцуулахад багассан боловч Даланзадгад сумын гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний өргөтгөлийн зураг төсвийн 63.4 сая төгрөгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

3.2.8 Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2²², Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12²³ дах заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


3.2.9 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг удирдлага мэдээллийн системд Гурвантэс, Номгон, Ханбогд сумд мэдээлэл оруулаагүй бол Булган, Сэврэй, Ноён, Ханбогд, Ханхонгор зэрэг сумдууд дутуу мэдээлсэн байна.

3.2.10 Энэхүү системийг бүрэн ашиглах нь төрийн байгууллага, албан тушаалтан хооронд мэдээлэл солилцож, аливаа төсөл хөтөлбөрийн хэрэгжиж буй эсэх асуудалд хяналт тавих боломж бий болж цаашид системээр дамжуулан мэдээллийн сан бүрдүүлж, хуваарилалт, төлөвлөлт хийх, төслийн санхүүжилт, гүйцэтгэлийг удирдах, тайлагнах, үнэлгээ хийх боломжтой юм.

3.2.11 Иймд системийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

3.2.12 Шилэн дансны цахим мэдээллийн системд аймгийн болон Гурвантэс, Цогтцэций сумдын ЗДТГ-ууд ОНХС-ийн мэдээллийг хугацаандаа мэдээлсэн бол бусад сумд хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

График-2 /ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг Шилэн дансны цахим системд хугацаа хоцроосон байдал/



²² Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

²³ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу төлөвлөсөн байна.
 - Иргэдийн санал аваагүй зарим төсөл арга хэмжээг баталсан байна.
 - Төсөл арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжийг баримталж хэрэгжүүлсэн байна.
 - Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.
 - ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалтад хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.
 - Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналт хангалтгүй байна.
 - Сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар журмын дагуу тайлагнаагүй байна.
-

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргад:

- ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ иргэдээс санал авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж байх,
- Хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналт, хөндлөнгийн хяналтыг сайжруулах,
- Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг удирдлага мэдээллийн системд бүрэн мэдээлж байх,
- ОНХС-ийн мэдээллийг шилэн дансны цахим мэдээллийн системд цаг хугацаанд нь оруулж байх,
- Даланзадгад сумын гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний өргөтгөлийн зураг 63.4 сая төгрөгийн ажлыг нягтлан бодох бүртгэлд тусгах,

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/114

Даланзадгад

「Аудитын тайлан баталгаажуулах тухай」

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг ахлах аудитор (Д.Сүрэнжаргал)-д үүрэг болгосугай.


С.ЦЭРЭНБАЯР

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”